

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Зуунмод

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

НЭГ. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ХАМРАЛТ, ДАМЖУУЛАЛТ

- Шалгуур 1 Мэдээний хамралт
- Шалгуур 2 Мэдээний дамжуулалт
- Шалгуур 3 Мэдээний бодит байдал, чанар
- Шалгуур 4 Хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн сан
- Шалгуур 5 Бизнес регистрийн мэдээллийн сан

ХОЁР. ТООЛЛОГО, СУДАЛГААНЫ АЖИЛ

- Шалгуур 6 Мал тооллого
- Шалгуур 7 Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
- Шалгуур 8 Ажиллах хүчний судалгаа
- Шалгуур 9 Эдийн засгийн түүвэр судалгаа

ГУРАВ. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

- Шалгуур 10 Сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа
- Шалгуур 11 Мэдээлэл тархаалт, вэб баяжилт

ДӨРӨВ. ДОТООД АЖИЛ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Шалгуур 12 Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа
- Шалгуур 13 Шилэн данс
- Шалгуур 14 Санхүүгийн үйл ажиллагаа

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

I БҮЛЭГ. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

Ш1: МЭДЭЭНИЙ ХАМРАЛТ:

Улсын мэдээ, тайлангийн график мөрдүүлэх тухай ҮСХ-ны даргын 2017 оны А/203 тоот тушаалыг хэрэгжүүлэн 2018 оны 12 сарын 14-ний байдлаар сар, улирал, жилийн давтамжтай 53 төрлийн албан ёсны статистикийн улсын мэдээ, тайлан, судалгаа, тооллогын мэдээллийг аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх төрлийн 24464 аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг хамруулан графикт хугацаанд нь үнэн зөв, бүрэн хамралттай гаргуулж, сумаас цахим холболтоор хүлээн авч нэгтгэн боловсруулж, хянаж ҮСХ-нд 213 удаагийн давтамжтайгаар бүрэн дамжууллаа.

Ш2: МЭДЭЭНИЙ ДАМЖУУЛАЛТ

ҮСХ-ны даргын баталсан графикийн дагуу мэдээ, тайланг хугацаанд нь бүрэн дамжуулж, хэлтсийн мэргэжилтэн бүр хариуцсан салбарын мэдээг онлайн болон офлайн программд бүрэн шивж, цахим хэлбэрээр medee@nso.mn хаягаар дамжуулж хэвшсэн.

Ш3: МЭДЭЭНИЙ БОДИТ БАЙДАЛ, ЧАНАР

1. Хэлтсийн салбар хариуцсан мэргэжилтнүүд аж ахуй нэгж, сумдаас мэдээ цуглуулахдаа анхан шатны мэдээний үнэн бодит байдал, баталгаажуулалт, өмнөх оны мөн үетэй харьцуулан хянаж, шалган авч нэгтгэл хийн боловсруулдаг. Мөн хөдөө аж ахуй болон бусад салбарын мэдээний хувьд нэгдсэн тоотой байх үүднээс аймгийн ХХААГ, УБХ болон бусад холбогдох агентлагуудтай хамтран ажиллаа. Хэрэглээний үнэ болон 7 хоногийн үнийн мэдээний бодит байдалд хэлтсийн дарга тогтмол тухайн цэгээсээ авч байгаа эсэхэд хяналт тавин ажиллаа.. 2017 оны жилийн эцсийн тайлан мэдээ ААНБ-1-ээр 207, Аж ахуй нэгж байгууллагын хураангуй мэдээ ААНБ-2-оор 670 аж ахуй нэгж байгууллагын мэдээллийг авч Сангийн яам, Татварын газрын мэдээтэй тулган шалгаж, тайлбарын хамт ҮСХ-ны сервэрт дамжуулсан.

ҮСХ-нд 2018 онд дамжуулсан мэдээ, тайлангийн тоо

	Мэдээ, тайлангийн нэр	Дамжуулсан мэдээний давтамж	Дамжуулсан мэдээнд хамрагдсан ААНБ, өрх
1	ХАА-1	5	485
2	ХАА-2	7	679
3	ХАА-3	12	324
4	ХАА-6	3	81
5	ХАА-7а	1	310
6	ХАА-7б	1	2061
7	ХАА-8	2	54
8	ХАА-9	1	3152
9	ХААБ-1	1	2
10	ААНБ-1,2	1	284
11	АҮ-1	11	297
12	АҮ-3	1	1
13	ХТ-1	1	1
14	ББО-1 /ААНБ-1.2/	5	368
15	ББӨ-1	3	8
16	Т-1	4	91
17	ШХИҮ-1	4	8
18	ХУ-1 /ААНБ1.2/	1	140
19	ХУ-1А	4	120
20	ЗГ-1 /ААНБ1.2/	1	16
21	ЗГ-1а	4	50
22	ЗБ-1 /ААНБ1.2/	1	11
23	ЗБ-1а	4	38
24	АЖ-1а	5	60
25	ХО-3б	3	27
26	БЗҮ-1	4	20
27	ҮНЭ-1	11	11
28	ҮНЭ-2	11	88
29	ҮНЭ-7	11	47
30	ХСҮ-1	6	39
31	ҮСҮ-1	3	12
32	ОС-1	1	182
33	НҮ-1	1	27
34	ХА-1	1	27
35	ХА-2	1	1
36	ХА-3	1	97
37	ҮХХ-1	1	9
38	БР-1	3	73
39	БР-2	1	1
40	СХ-1	4	24
41	ЭШС-1	4	28
42	ХО1	3	39
43	ТББ-1	4	96
44	МТС-1а	4	10
45	АҮҮИ	12	60
46	МЭ-1	4	298
47	НБХҮ1	3	18
48	ОСНАА-1	1	1
49	ӨНЭЗС	12	614
50	АХС	12	480
51	АХС-туршилт	6	170
52	МТ -хагас жил	1	2415
53	МТ - жил (12 сарын 14 байдлаар) дутуу	1	10919
	Дамжуулсан мэдээний тоо, төрөл	213	24474

Ш4: ХҮН АМ, ӨРХИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

Сумдын статистик хариуцсан ажилтан, БЗД болон Зуунмод сумын багийн бүртгэл мэдээлийн ажилтан нарт ХАӨМС-гийн тайлан хүснэгтийн хүн амын тайлан, өрхийн тайлан хүснэгтүүдийг нэг бүрчлэн уншуулж түүн дээр гарч байгаа алдааг нэг бүрчлэн засах, мөн өрх нэг бүрээр орж өрхийн үзүүлэлт, хүн амын үзүүлэлтийн мэдээллийг шинэчилэх, өрхийн байршлыг оруулах, мэдээлэл үнэн зөвийг засуулахад зөвлөн туслаж 27 сумын 97 багийг хуваарилан авч ажилласнаар ХАӨМС-тай холбоотой бүх алдаа засваруудыг засуулахын зэрэгцээ программ хангамжийн асуудлыг шийдэн, сум багийн статистик хариуцсан ажилтан, Зуунмод сумын багийн зохион байгуулагч нарт ХАӨМС-гийн тайлан хүснэгтийн хүн амын, өрхийн тайлан хүснэгтүүдийг нэг бүрчлэн уншуулж түүн дээр гарч байгаа алдааг нэг бүрчлэн засах, мөн өрх нэг бүрээр орж өрхийн үзүүлэлт, хүн амын үзүүлэлтийн мэдээллийг шинэчилэх, мэдээлэл үнэн зөв эсэхэд анхаарч ажиллаа.

2018 оны эхний 5 сард хүн амын алдааны 10, байршил орууллаагүй өрх, өрхийн сууцны нөхцөл хэсгийн алдааны 16 төрлийн жагсаалтыг 27 сум, 97 багт 5 удаа ДУС-ээр сумын ЗД, ЗДТГ-ын болон санхүүгийн албаны дарга, сум, багийн статистик хариуцсан ажилтан нарт хүргүүлж, 98.7-100 хувь арилгууллаа. ХАӨМС-д 2018 оны эхний 5 сард төрсөн хүүхдийг бүртгэж оруулах, иргэн болон өрхийн шилжилт баталжуулгах, хүлээгдэж буй шилжилт хөдөлгөөнийг бууруулах, өрх нэг бүрээр орж мэдээллийг шинэчилэн алдааг засах ажлуудыг хийв.

Хэлтсийн мэргэжилтнүүд 27 сумыг хуваан хариуцаж, ХАӨМС-тай холбоотой бүх алдаа засваруудыг засуулахын зэрэгцээ программ хангамжийн асуудлыг шийдэн ажиллаа. Сумдын статистик хариуцсан ажилтан, багийн Засаг дарга болон Зуунмод сумын багийн нийгмийн ажилтануудад ХАӨМС-гийн тайлан хүснэгтийн хүн амын тайлан, өрхийн тайлан хүснэгтүүдийг нэг бүрчлэн уншуулж түүн дээр гарч байгаа алдааг нэг бүрчлэн засах, мөн өрх нэг бүрээр орж өрхийн үзүүлэлт, хүн амын үзүүлэлтийн мэдээллийг шинэчилэх, мэдээлэл үнэн зөв эсэхэд анхаарч ажиллаа.

УБХ-тэй хамтарч 2018 оны эхний 1-5 сард төрсөн хүүхэд 889; нас барсан хүн 242; бусад аймаг, хот руу шилжин явсан 529; бусад аймаг хотоос шилжин ирсэн 884 хүн бүртгэгдснийг сар бүр танилцууллагад оруулан ажилласнаар төрсөн хүүхдийн 92.5, нас барсан хүний 100.0 хувь нь ХАӨМС-д орууллаа.

Ш5: БИЗНЕС РЕГИСТРИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

2018 оны эхний 5 сард улсын бүртгэлийн хэлтэс, сумдын татварын байцаагч, сумдын статистик мэдээ хариуцсан ажилтан нартай хамтарч шинээр байгуулагдсан аж ахуй нэгжийг ҮСХ-оос баталсан БР-1, БР-2 маягтын үзүүлэлтийн дагуу гаргаж нийт 73 ААНБ-ийн тодруулгыг бүртгэж ҮСХ-нд дамжууллаа. Цаашид Улсын бүртгэлийн сангаас сар бүр өөрчлөлт шинэчилэлт орсон аж ахуй нэгж байгууллагыг нэрсийн жагсаалтаар авч бизнес регистрийн санд өөрчлөлт хийхээр хэрэгжүүлэн ажиллаа.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2018 оны эхний 5 сард нийт 76 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 44; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 11; нөхөрлөл /ЗБН/ 13, /ББН/ 1; Хоршоо 2; сан 2; банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ 3 тус бүр бүртгэгдснийг сар бүр сумдаар танилцууллагад оруулан ажилладаг болсон.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2018 оны эхний 5 сард 115 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 33; гишүүн нэмэгдсэн хасагдсан 3; дүрэм шинэчилсэн 4; дахин гэрчилгээ 15; удирдлага өөрчлөгдсөн 24; үйл ажилгааны чиглэл өөрчлөгдсөн 12; дүрмийн сан нэмэгдсэн хасагдсан 10; хаяг өөрчлөгдсөн 1; нэр хэлбэр өөрчлөгдсөн 2; татан буугдсан 8; өв залгамжлал 2; салбар бүртгүүлсэн 1 тус бүр бүртгүүлээ.

II БҮЛЭГ. ТООЛЛОГО, СУДАЛГААНЫ АЖИЛ

Ш6: Мал тооллого

Бэлтгэл ажил, зохион байгуулалт: Хагас жилийн малын түүвэр судалгааг 2018 оны 6 дугаар сарын 4-11-ний өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлын бүрэн хангаж ажиллаа. Аймгийн засаг даргын А/0164 дугаар тоотыг боловсруулан гаргуулж үүний дагуу 27 сумдад тооллого зохион байгуулж явуулах сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсгийг сум бүрд байгуулж судалгаанд ажиллах төрийн албан хаагчийг томиллоо. 5 дугаар сарын 30-ны өдөр мал тооллогын цахим сургалт хийсэн. Семинар сургалтад сумдын ЗД, ЗДТГ-ын дарга, мал үржлийн албаны дарга, сум багийн статистик хариуцсан ажилтнууд оролцож малын түүвэр судалгааны удирдлага зохион байгуулалт, тооллогын программын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Мал тооллогын судалгааны маягт, түүвэрт хамрагдах өрхийн жагсаалтыг судалгаа эхлэхээс өмнө сумдад хуваарилан хүргүүлж мал тооллогын шивэлтийг программыг 27 сумдад суулгаж өгч туршилтийн шивэлт хийсэн. Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулж сумдад хуваарилан хүргүүлсэн. Судалгааны санхүүжилт нийт 15 751 250 төгрөгийг сумдад хуваарилан тооллого эхлэхээс өмнө замын зураглалыг гаргаж судалгаанд сонгогдсон өрхийн байршлыг тогтоож бэлтгэл ажлыг хангууллаа. 6 дугаар сарын 4-11 өдрүүдэд хагас жилийн малын түүвэр судалгаа амжилттай явагдаж 2396 өрх, 19 аж ахуй нэгж байгууллага нийт 2415 өрх, ААНБ тооллогод бүрэн хамрагдлаа. Тооллогын асуулгын хуудсыг <http://maldb.nso.mn/livestock2013/> онлайн программд шивэлт хийж ҮСХ-ны серверт дамжууллаа. 2018 оны мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын асуулгын хуудас, маягт нөхөх зааврыг сумдад хүргүүлж бэлтгэл ажлыг хангууллаа. 27 сумын ИТХ-ын дарга, нарын бичгийн дарга, ЗД, түүний орлогч, ЗДТГ-ын дарга, Санхүү албаны дарга нар оролцсон цахим сургалт зохион байгууллаа. Аймгийн төвд 27 сумын 97 багийн Засаг дарга нарт мал тооллогын талаар чиглэл өгч анхаарах асуудал өмнөх онд гарсан алдаа дутагдлыг анхаарууллаа. Мөн 12 сарын 5-ны өдөр 27 сумын Статистик хариуцсан ажилтан нарт тооллогын асуулгын хуудас нөхөх

заавар, баримтлах зарчим, анхаарах үүрэг болгох асуудал, өмнөх онд гарсан алдаа дутагдал, малчин өрхийг тооллогод бүрэн хамруулах талаар заавар зөвлөгөө өгч нийт 27 сумын **286** төрийн албан хаагч хамрагдлаа. Мал тооллогын livestock, livestockreport программуудыг сумдад хүргүүлж суулгагдахгүй компьютерт teamviewer программаар удирдаж суулгалаа. Өдөр бүр сумдын мал тооллого болон программтай холбогдон гарсан асуудлыг аймаг, ҮСХ-той холбогдож шийдвэрлэж, өрхийн тэргүүлэгч солих, нас барсан, шинээр нэмэгдэж буй аж ахуйн нэгжүүдийг ҮСХ-нд дамжуулж программд орууллаа. 2018 оны 12 сарын 13-ны байдлаар 27 сумын 95 багийн 8686 мал бүхий өрх, 36 аж ахуйн нэгж, 8 тавиул малтай өрхийн мэдээллийг орууллаа.

Ш7: ӨНЭЗС-г 2018 онд таблет ашиглан зохион байгуулж түүвэрт сонгогдсон 71 нэгжийн нийт 614 өрхөд судалгааг явуулж ҮСХ-нд хугацаанд нь бүрэн дамжууллаа. 2017 оны IV, 2018 оны I-III улирлын үр дүнгүүдийг хэлтсийн сайтад байрлуулж, ДУС-ээр үндсэн бүх хэрэглэгч нарт тархаасан. **Ардчилсан засаглал судалгааг** АЗС-г 2018 онд түүврийн 18 нэгжийн нийт 160 өрхөөс авч ҮСХ-нд хугацаанд нь дамжуулав.

Ш8: Ажиллах хүчний судалгааг АХС-г 2018 онд 40 түүврийн нэгжийн нийт 480 өрхөөс батлагдсан маягтаар таблет ашиглан цуглуулж, хугацаанд нь ҮСХ-нд дамжуулав.

Ажиллах хүчний туршилтын судалгааг АХС-г 2018 онд 17 түүврийн нэгжийн нийт 170 өрхөөс батлагдсан маягтаар таблет ашиглан цуглуулж, хугацаанд нь ҮСХ-нд дамжуулав. 2017 оны IV, 2018 оны I-III улирлын үр дүнгүүдийг хэлтсийн сайтад байрлуулж, ДУС-ээр үндсэн бүх хэрэглэгч нарт тархаасан.

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “е”-д “нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааг 3 жил тутам”-д зохион байгуулахаар заасны дагуу Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан болон Хүн амын сангийн хамтарсан санхүүжилтээр тус судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2018 оны 11-12 саруудад Зуунмод сумын I, V баг, Алтанбулаг сумын IV баг, Батсүмбэр сумын III баг, Баян-Өнжүүл сумын II баг, Баянчандмань сумын II баг, Бүрэн сумын II баг, Жаргалант сумын II баг, Лүн сумын I баг, Сэргэлэн сумын I баг, Эрдэнэ сумын II баг, 10 сумын 11 багийн 275 өрхийн санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон өрхүүд хамрагдлаа. Судалгааг зохион байгуулах, бэлтгэл ажлын хүрээнд аймгийн ЗД-ын 2018 оны 8 сарын 01/1603 дугаарын албан тоотыг түүвэрт сонгогдсон сумдад хүргүүлж судалгааны багт дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллав.

Ш9: Эдийн засгийн түүвэр судалгаа

Зочид буудал, зоогийн газрын судалгааг сонгогдсон 3 аж ахуй нэгж байгууллагаас авч ҮСХ-нд тушаалаа.

Тээврийн индекс тооцох судалгааны жин, сагс бүрдүүлэх судалгааг Зуунмод сумаас сонгогдсон 3 аж ахуй нэгжээс судалгааг авч дамжуулсан.

Үйлдвэрийн газрын бүтээгдэхүүний нэр төрлийн судалгааг Батсүмбэр, Баянцагаан, Мөнгөнморьт, Зуунмод сумдад сонгогдсон 5 аж ахуй нэгж байгууллагаас авч ҮСХ-нд дамжуулсан.

III БҮЛЭГ. СТАТИСТИКИЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ

Ш10:СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

СУМДЫН ИТХ-ЫН ДАРГА, ЗАСАГ ДАРГА, ЗДТГ-ЫН ДАРГА НАРЫН СУРГАЛТ

2018 он 02 сар 07

Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын сургалт, семинарыг Засгийн газрын болон бүх шатны Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, сумын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, “Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих жил” урианы бодлого хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулахад бодлогоор дэмжиж, арга зүйн зөвлөгөө зөвлөмж өгөх зорилгоор аймгийн ЗДТГ зохион байгууллаа.

Сургалт, семинарын үеэр аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтсийн дарга нар болон Засаг даргын дэргэдэх агентлагийн дарга нар 2018 оны дэвшүүлсэн зорилт, анхаарах асуудлаар чиглэл өгч, гарын авлагаар хангав

БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН СУРГАЛТ 2018 он 04 сар 04.

Монгол улсын Засгийн газрын болон аймаг сум, багийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг сумын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих урианы жилийн хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газраас төрийн үйлчилгээний анхан шатны нэгж болох баг, багийн Засаг дарга нарыг чадавхижуулах сургалтыг зохион явуулж байна. Урианы жилийн хүрээнд төлөвлөгдсөн ажил, хөтөлбөрүүдийг орон нутагтаа хэрэгжүүлэхэд нь бодлогын зөвлөгөө, дэмжлэг өгөхөд сургалтын зорилго, ач холбогдол чиглэгдэж байгаа бөгөөд сургалтад 27 сумын 97 багийн Засаг дарга нар хамрагдлаа.

АЛБАН ЁСНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ ГАРГАХАД БАГИЙН ЗАСАГ ДАРГЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, АНХААРАХ АСУУДАЛ сэдвээр 2020 оны Хүн ам, орон сууцны улсын ээлжит тооллогын тухай; Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн өрх, хүн амын үзүүлэлтүүдийн бүрэн нөхөлт, мэдээллийн чанар, үнэн бодит байдлыг сайжруулах; Гудамж, зам талбай, барилга, орон сууц, хашаа, хаалганы хаягжуулалтыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын хийсэн шинэ хаягийн зургийн дагуу шинэчлэх ажлыг эрчимжүүлэх; Багийн харъяат үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, ААНБ-ын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээг албан ёсны статистик мэдээлэлд бүрэн хамруулах; 2017 оны мал тооллогын анхаарах асуудал сургамжууд; сум, багийн албан ёсны статистик мэдээллээр танилцуулга бэлтгэж, байнгын сурталчилгааны самбар ажиллуулах зэрэг чигллээр мэдээлэл өглөө.



Сумдын статистик хариуцсан ажилтнуудын сургалт семинар. 2018 он 05 сар 15

2018 оны 5 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд аймгийн төв Зуунмод суманд Статистик хариуцсан ажилтан нарт зориулсан сургалт боллоо. Сургалтанд 27 сумын санхүү албаны дарга, сумын статистик хариуцсан ажилтан нийт 54 хүн хамрагдлаа.

Сургалтаар хэлтсийн дарга болон салбар хариуцсан мэргэжилтнүүд сар, улирал, жилийн мэдээ тайлан гаргах, мэдээний чанар, бодит байдалд хяналт тавих, мэдээний үндсийг баталгаажуулах болон цаашид анхаарах асуудлаар заавар, аргазүйн зөвлөгөө өглөө. Мөн "Зөрчлийн тухай хууль"-д статистикийн мэдээ тайланг хоцроосон, өгөөгүй, алдаатай мэдээлсэн хуулийн этгээдэд авах арга хэмжээний талаар, статистикийн хэлтсээс хэрэгжүүлж байгаа шинэлэг ажил, 2018 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд, ҮСХ-оос явуулах томоохон түүвэр судалгаа, цаг үеийн ажлын талаар мэдээлэл хийлээ.



2018 оны 5 сарын 30-ны өдөр 2018 оны хагас малын түүвэр судалгааны цахим семинар-сургалтыг сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, санхүүгийн болон мал үржлийн албаны дарга нар, олон нийтийн интернэт мэдээллийн төвийн ажилтан, сумбагийн статистик хариуцсан ажилтнуудад зохион байгуулан малын түүвэр судалгааны зохион байгуулалт, тооллогын маягт, аргачлал, программын талаар дэлгэрэнгүй заавар зөвлөмж өгч ХАӨМС-гийн болон бусад мэдээ тайлангийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл зааварчлага өглөө. Сумдаас малын түүвэр судалгаа болон ХАӨМС-гийн чигллээр

гарсан асуултанд статистикийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд дэлгэрэнгүй хариулт өглөө. Сургалтын бүрэн хэмжээний аудио бичлэгийг сумдад дотоод удирдлагын системээр дамжууллаа.

ЕБС-ын ахлах ангийн 763 сурагчид “Статистикийн боловсрол” хичээлийг 23 сумын статистик хариуцсан ажилтнууд 11 сард заав.

2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 2018 оны Мал, тэжээвэр амьтадын улсын тооллогын цахим семинар-сургалтыг сумдын удирдлага нарт АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД МАЛ ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА Ж.БАТЖАРГАЛ, статистикийн хэлтсээс зохион байгуулан явууллаа. Семинар сургалтанд сумдын Засаг дарга, орлогч, ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга, санхүү албаны дарга, олон нийтийн интернэт мэдээллийн төвийн ажилтан, сумын статистик хариуцсан ажилтнууд оролцож мал тооллогын зохион байгуулалт, тооллогын маягт, аргачлал, программын талаар дэлгэрэнгүй заавар зөвлөмж өгч ХАӨМС-гийн болон бусад мэдээ тайлангийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл зааварчлага өглөө.





2018 оны 11 дүгээр сарын 28,29-ны өдөр Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд 2018 оны Мал, тэжээвэр амьтад, малын хашаа, худгийн тооллогын сургалтыг сумдын багийн Засаг дарга нар оролцож асуулгын хуудас нөхөх заавар, тооллогын зохион байгуулалт, тооллогын зарчим, тооллогын хамрах хүрээ, энэ жилийн тооллогын онцлог, анхаарах, үүрэг болгох асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл хийлээ. Мөн ХАӨМС-ын баяжилт хөтлөлт, нийгмийн үзүүлэлтийн шинэчилсэн маягтай холбоотой маягт хэрхэн нөхөх, мэдээний урсгал, программд шивэх асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Багийн Засаг дарга нараас асуусан асуултад хэлтсийн дарга, салбар хариуцсан мэргэжилтэн нар тодорхой хариулт өглөө.



МОНЦАМЭ агентлагийн цахим сувгаар 2 мэдээ, орон нутгийн ТБС, ТУВ телевизээр сар бүр 3-5 удаа мэдээлэл бэлтгэн нэвтрүүлж олон нийтэд үйлчлэв. Аймгийн төвд байрладаг урсдаг самбараар статистикийн 1-11 сарын танилцуулга, тооллого судалгаа, цаг үеийн мэдээ, мэдээллийг хэрэглэгчдэд хүргэж байна.



Аймгийн засаг даргын тамгын газрын хүлээлгийн зааланд электрон самбарыг байршуулан статистикийн мэдээ, мэдээллээ хэрэглэгчдэд үйлчилж байна.



Ш11: МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ, ВЭБ БАЯЖИЛТ

Аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын тухай 2017 оны эцэс, 2018 оны эхний 1-11 сарын танилцуулга бэлтгэн гаргаж ИТХ, Засаг дарга, Тамгын газрын бодлогын хэлтэсийн дарга нар болон нийтийн номын сан, нэг цэгийн үйлчилгээний хэрэглэгчидэд хэвлэж тархаалаа. Хэлтэс агентлагын дарга, УИХ-ын гишүүдэд сарын танилцуулгыг цахим хаягаар дамжуулж хэвшлээ.

2017 оны жилийн эцсийн нийгэм эдийн засгийн гол үндсэн 32 үзүүлэлтээр 27 сумаар, 15 үзүүлэлтээр 97 багаар эрэмбэ, зиндааг гаргаж үндсэн хэрэглэгчдэд хэвлэж болон ДУС-ээр, бусад хэрэглэгчдэд цахимаар тархааж үйлчлэв. Орчин үе өргөн хэрэглээний онлайн хуудсанд мэдээллийг байршуулж хэрэглэгчдэд хурдан шуурхай хүргэх зорилгоор хэлтэстээ фэйсбүүк хуудсыг [/https://www.facebook.com/statistik](https://www.facebook.com/statistik) нээж ажиллууллаа.

Хэлтсийн вэб сайтыг нүүр хуудас, байгууллагын үйл ажиллагаа, бюллетень танилцуулга, тооллого судалгаа, бизнес регистрийн сан, хүн амын орон сууцны тооллого, шилэн данс, динамик эмхэтгэл, дотоодын нийт бүтээгдэхүүн, мэдээлэгч, хэрэглэгч нарт, хүний нөөц, статистикийн ангилал, код дэд цэсүүдээр он оноор нь байршуулан бүх төрлийн хэрэглэгч нарт үйлчлэв. 2018 онд нийт 21 мэдээ; сар, улирал болон сэдэвчилсэн 23 судалгаа, танилцуулга, инфографик; хүн ам, ХАА, бизнес регистрийн шинэ болон шинэчилсэн 15 динамик; 21 бусад шинэчлэгдсэн маягтуудыг байршуулав. 2018 онд нийт хандсан хэрэглэгчийн тоо **87295**-д хүрлээ. Хэрэглэгчийн программ <http://web.nso.mn/crm>-д 2018 он гарсаар 115 хэрэглэгч статистикийн тоон мэдээллээр үйлчлүүлж бүртгүүлээ. ҮСХ-оос тархаахыг зөвшөөрсөн үзүүлэлтүүдээс Хүн ам, Бүртгэлтэй ажилгүй иргэд, ХАА, Нийгмийн даатгал, Гэмт хэрэг, Үнэ, Аж үйлдвэр, Мөнгө санхүү, Төсвийн орлого, зарлага зэрэг 9 салбарын үзүүлэлтээр инфографикийг эхний 5 сарын байдлаар бэлтгэн [tuv.nso.mn](http://web.nso.mn) веб сайтад байршуулан тархаалаа.

Динамик эмхэтгэлийг 2017 он хүртэл дараахь салбарын үзүүлэлтүүдээр баяжуулж сайтад байрлуулан хэрэглэгч нарт үйлчилсэн.

Ерөнхий тэмдэглэгээ Товчилсон тэмдэглэл

Нутаг дэвсгэр, хилийн урт

Нутаг дэвсгэрийн хэмжээ, багийн тоо

УИХ, аймгийн ИТХ-ын сонгууль 1992-2016

Сүмдын ИТХ-д сонгогдсон төлөөлөгчийн тоо, намын харъяаллаар 1996,2004,2012,2016

Хүн ам, нийгмийн үзүүлэлт

- Суурин хүн амын тоо, сум багаар насны бүлгээр 2017 [xls](#)

Мал аж ахуйн үзүүлэлт

- Малчид, малчин, малтай өрхийн тоо сумаар **1993-2017** [xls](#), [pdf](#)
- Иргэдийн хувийн бүлэглэлт- сумаар, бүлгээр **1992-2017** [xls](#), [pdf](#)
- Малын тоо-сумаар, өрлөөр **1960-2017** [xls](#), [pdf](#)
- Хээлтэгч малын тоо-сумаар, төрлөөр **1961-2017** [xls](#), [pdf](#)
- Хүнсэнд хэрэглэсэн мал төрлөөр, сумаар **1961-2017** [xls](#), [pdf](#)
- Том малын зүй бус хорогдол, хорогдсон төл **1961-2017** [xls](#), [pdf](#)

**2018 онд Дотоод удирдлагын системээр (ДУС) хэрэглэгчид
статистикийн ажил-үйлчилгээ тархаасан байдал
27 сумын бүх төсвийн байгууллагууд, алба, хэлтэс, газар**

Статистикийн ажил-үйлчилгээний төрөл		Хүлээн авсан хэрэглэгчдийн тоо
Аймгийн нийгэм эдийн засгийн танилцуулга		
1	2017 он 12 сар	552
2	2018 он 1 сар	518
3	2018 он 2 сар	609
4	2018 он 3 сар, инфографиктай	591
5	2018 он 4 сар, инфографиктай	585
6	2018 он 5 сар, инфографиктай	591
7	2018 он 6 сар, инфографиктай	587
8	2018 он 7 сар, инфографиктайр	639
9	2018 он 8 сар, инфографиктай	671
10	2018 он 9 сар инфографиктай	732
11	2018 он 10 сар инфографиктай	767
12	2018 он 11 сар инфографиктай	441
13	Мал тооллогын 2017 оны улс, аймгийн урьдчилсан дүн	572
14	Аймаг, сум, багийн нийгэм, эдийн засгийн зарим үзүүлэлтийн 2017 оны эрэмбэ зиндаа	518
15	Цалингийн 2017 оны 4 дүгээр улирлын үр дүн	609
16	Өрхийн нийгэм эдийн засгийн 2017 оны 4 дүгээр улирлын үр дүн	609
17	Ажиллах хүчний судалгааны 2017 оны 4 дүгээр улирлын үр дүн	609
18	"Үндэсний статистик" сэтгүүлийн 2017 оны 4 дахь дугаар.	609
19	EVIEWS 9 ПРОГРАМЫГ ШИНЖИЛГЭЭНД АШИГЛАХ НЬ	609
20	БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ҮЗЛЭГ ТООЛЛОГО-2017	591
21	Цалингийн 2018 оны 1 дүгээр улирлын үр дүн	591
22	Өрхийн нийгэм эдийн засгийн 2018 оны 1 дүгээр улирлын үр дүн	591
23	Ажиллах хүчний судалгааны 2017 оны 1 дүгээр улирлын үр дүн	591
24	0. Оршил	617
25	1. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХУЧИРХИЙЛЛИЙН СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮНГ ТАРХААХ СЕМИНАР	617
26	2. ХАМТРАГЧИЙН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХУЧИРХИЙЛЭЛ	617
27	3. БУСДЫН ЗҮГЭЭС ҮЙЛДСЭН ХУЧИРХИЙЛЭЛ	617
28	4. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн олон улсын болон бүс нутгийн дүр төрх	617
29	5. Судалгааны нугалбар	617
30	6. Судалгааны инфографик	617
31	7. ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХУЧИРХИЙЛЛИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН-2017	617
32	ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ 2017 ОНЫ ТАНИЛЦУУЛГА	587
33	Хөдөө аж ахуйн салбар 2017	639
34	Аймгийн хүн ам, нийгмийн зарим үзүүлэлт 2017 онд, инфографик	639
35	ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ 2018 оны 2 дугаар улиралд ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНИЙН ИНФЛЯЦАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ БА БОГИНО	639
36	ХУГАЦААНЫ ИНФЛЯЦЫН ТААМАГЛАЛ	639
37	ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД 2017 ОНД	639
38	Хөдөө аж ахуйн салбар 2017-ҮСХ	671
39	ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА 2018 оны 2 дугаар улиралд	671
40	Ажиллагчдын дундаж цалин 2018 оны 2 дугаар улиралд	671
41	Төв аймгийн ДНБ-ий үйлдвэрлэл буюу нэмэгдэл өртөг, 2010-2017 он	732
42	БҮС НУТГИЙН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН 2017 ОНД ҮСХ	732
43	"Ардчилсан засаглал судалгаа"-ны 2009-2017 оны үр дүн	732
44	ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР- 2017 ҮСХ	732
45	ГАДААД ХУДАЛДАА 2017-ҮСХ	732
46	МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН-ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ДАНСУУД ҮСХ	732
47	ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ 2017 ОНД ҮСХ	732
48	БҮС НУТГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХАРЬЦУУЛСАН	767
49	Төв аймгийн 2017 оны лавлагаа	441
50	ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ 2018 оны 3 дугаар улиралд	441
51	ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА 2018 оны 3 дугаар улиралд	441
Бүгд		31736

IV БҮЛЭГ. ДОТООД АЖИЛ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шалгуур 12 Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа

Шалгуур 13 Шилэн данс

Шалгуур 14 Санхүүгийн үйл ажиллагаа

Ш12: АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ, АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Монгол Улсын статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-, “Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр” зэрэг холбогдох хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу төсвийн Ерөнхийлөн захирагч ҮСХ-ны дарга болон аймгийн Засаг даргатай үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хугацаанд нь тайлагнан ажиллаа. 2018 онд аймгийн Засаг даргатай хэлтсийн даргын байгуулсан гэрээний биелэлт, үйл ажиллагааны үр дүнг 94.2 хувь буюу “Бүрэн хангалттай” гэж дүгнэлээ. Хэлтсийн дарга хэлтсийн ажилтнуудтай үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр дүгнэлээ. Хэлтсийн 5 ажилтан 2018 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр “В” үнэлгээтэй дүгнэгдлээ.

Сар, улирал, жилийн танилцуулгын тайлбар болон хүснэгтийн үсгийн хэмжээг 10-12, бичвэрийг Mongolian (Cyrillic) байх, график нь энгийн ойлгомжтой фон нь тухайн салбарын онцлогийг тусгасан, газрын зураг нь бүх сумдыг хамруулж оновчтой үзүүлэлтээр илэрхийлэгдсэн байх зэрэг стандартуудыг мөрдөж хэрэгжүүлэн улам бүр боловсронгуй болгох зорилт тавин ажиллаа.

2018 оны эхний 11 сард явуулсан албан бичиг 21, ирсэн албан бичиг 50, үүнээс 23 нь хугацаатай байсныг хугацаанд шийдвэрлэсэн. 2017 оны албан хэргийг байгууллагын архивт хүлээлгэн өгсөн. ҮСХ-ноос хэлтсийн албан бланкуудыг шинээр хэвлүүлж өгсөнг мөрдөж ажиллаа.

Ш13: ШИЛЭН ДАНС

Шилэн дансны цахим хуудсанд эхний 11 сарын байдлаар хэлтсийн 2018 оны батлагдсан төсөв, түүний гүйцэтгэл, гарсан зардал, орлого, зарлагын гүйлгээний мэдээ, 5 сая ₮-өөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, цалингийн зардлаас бусад 5 сая ₮-өөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, 2017 оны жилийн эцсийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлт болон аудитын зөвлөмжийн хариу зэрэг нийт 65 нэр төрлийн мэдээг шилэн дансны цахим хуудас болон мэдээллийн самбарт цаасан хэлбэрээр байршуулан олон нийтэд мэдээллээ. Шилэн дансны хуулиар 124 төрлийн мэдээ, тайлан, хавсралтыг байршууллаа. 2018 оны эхний 11 сарын үндсэн санхүүжилт 64.4 сая.₮, нэмэлт санхүүжилт 80.6 сая ₮-ийг хөтөлбөр, зориулалт арга хэмжээний дагуу зарцуулж өр, авлагагүй ажиллан 2017 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж тушаасан.

Ш14: САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Санхүүгийн тайлан стандарт программын хэрэглээ.

2018 оны жилийн хэлтсийн үйл ажиллагаанд зарцуулагдах батлагдсан төсвийг зардлын зүйлээр зориулалтын дагуу зарцуулж өр, авлагагүй ажиллаа. **ACOLOUS 3.0**, цалин хөлсний **PAYROLL 2.0** программаар санхүүгийн тайлан балансыг хуулийн хугацаанд гаргаж ҮСХ-нд хуулийн хугацаанд хүргүүлээ. Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэст тайланг хугацаа хожимдолгүй өр, авлага үүсгэлгүй хуулийн хугацаанд гаргаж хүргүүлэн ажиллаж байна. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн төсөв санхүүгийн ил тод байдлын мэдээллийн самбарт хэлтсийн жилийн санхүүгийн тайланг бүрэн эхээр, тухайн жилийн батлагдсан төсвийг жил, сараар, сар бүрийн төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийг олон нийтэд нээлттэй байх зарчмыг баримтлан <http://shilendans.gov.mn/> портал сайтад сар бүр байршууллаа.

- **Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн тайлан.**
- Байгууллагын эд хөрөнгийг хууль тогтоомж болон Төрийн өмчийн хорооноос гаргасан шийдвэрийн дагуу НББ-д тусган Төрийн өмчийн хорооны **e-spc.gov.mn** сайтад 2017 оны жилийн эцсийн хөрөнгийг шивэн баталгаажуулж өмчийн тайланг хугацаанд нь тушаалаа.
- **Төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээний гаргалт**
- Төсвийн гүйцэтгэлийн тайланг сар бүр хуулийн хугацаанд гарган хэлтсийн даргаар хянуулан, санхүү төрийн сангийн хэлтсээр баталгаажуулж Үндэсний статистикийн хороонд хүргүүлэн ажиллахаас гадна, төсвийн сахилга хариуцлагыг баримтлан, төсвийн нээлттэй ил тод байдлыг хангах үүднээс сарын мэдээг хэлтсийн вэб сайт **tuv.nso.mn** болон шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх үүднээс <http://shilendans.gov.mn/> портал сайтад байршууллаа.
- Аймгийн Аудитын газраар 2017 оны санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгад стандарт журмын дагуу баталгаажуулах аудит хийлгэж зөрчилгүй санал дүгнэлт гаргуулан өгсөн зөвлөмжийг санхүүгийн бүртгэл тайландаа тусган шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх үүднээс <http://shilendans.gov.mn/> портал сайтад байршууллаа.

ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН ӨГӨӨЖ

Цуглуулсан мэдээ, тайлангийн үзүүлэлт хоорондын уялдаа, бүрэн нөхсөн байдал, оронгийн болон цэг, таслалын алдаатай шивсэн эсэх, үзүүлэлтийг маягтад заасан хэмжих нэгжээр тооцсон зэрэгт аргачлалын дагуу шалгалт хийхийн зэрэгцээ үзүүлэлт нэг бүрээр нягтлан шалгаж, илэрсэн алдааг засч, үзүүлэлт хэт өсч буурсан зөрүүтэйд анхаарч ажиллахыг 27 сумын статистик мэдээ хариуцсан ажилтнуудад сургалтын үеэр

зөвлөлөө. Хэлтсийн салбар хариуцсан мэргэжилтнүүд аж ахуй нэгж, сумдаас сар , улирал, жилийн эцсийн мэдээ цуглуулахдаа мэдээ, тайлангийн бодит байдлыг нягталж, мэдээнд хамрагдсан ААНБ-ын мэдээлэл нэг бүрийг өмнөх оны мөн үе болон тухайн оны өмнөх улиралтай нь харьцуулан тулгалт хийн шалгаж, мэдээлэл цуглуулсан сумын статистикийн ажилтнаас тодруулга авч нягтлах, шивэлтийн алдааг залруулах, мэдээлэл алдаатай ирүүлсэн тохиолдолд мэдээллийг засч ҮСХ-нд алдаагүй болгон дамжууллаа.

2018 оны 1 сард Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, 2 сард Баянцагаан, 3 дугаар сард Батсүмбэр, Эрдэнэсант, 4 сард Жаргалант, Цээл, Угтаал, Лүн, Баян, 5 сард Заамар, Эрдэнэ сумдаар хяналт шалгалт хийж хүн ам өрхийн бүртгэлийн программын хөтлөлт, баяжилт, хөдөө аж ахуйн салбарын мэдээ, аж үйлдвэрийн мэдээний үндэс, чанар, бодит байдалд шалгалт хийж алдаа дутагдлыг залрууллаа. Багийн даргаас ирж байгаа анхан шатны мэдээ төллөсөн эх мал, гарсан төл, хорогдсон төл, том малын зүй бус хорогдол, өвчнөөр хорогдсон том малын мэдээг шалгаж зөвлөмж хүргүүллээ. Сумдад гарч байгаа нийтлэг алдаа хорогдлын мэдээг багийн бүх өрхөөс асууж мэдээнд хамруулаагүй, хамралт бага мэдээний чанар тааруу байгаа алдааг цаашид гаргахгүй байхыг анхаарууллаа.

Аймгийн төвийн 6 багийн иргэдээ сонсох арга хэмжээнд оролцож 12 өрхийн гишүүдээс Хүн ам, өрхийн мэдээлэлийн санд байгаа тухайн өрхийн болон бүх гишүүдийн мэдээлэлийг нягтлан шалгаж үзэхэд боловсрол, ажил эрхлэлт, сууцны талбайн хэмжээ зэрэг үзүүлэлтүүд зөрүүтэй байсанг залрууллаа. Цаашдаа багийн Засаг дарга, зохион байгуулагч нарт бүх өрх, түүний гишүүдийн мэдээлэлийг нягтлан шалгаж ажиллахыг зөвлөмж болгов.

2018 оны эхний улирлын түүвэрт орж үйл ажиллагаа явуулаагүй гэсэн НУУЦ ТОВЧОО, ТАЛЫН НҮҮДЭЛЧИД, БАЯНСОНГИНОТ ЭКО, ВАЙЛДВОЛЬФ ТУР, ХАЙРТХААН, ЭС ТҮШИГ БУУРАЛ, МЭГЕНЕ, АГРАН, ХӨГЖЛИЙНБУЛАГ, ДЭЛГЭРТҮШЭЭТХАН, ОДОТТЕХНИК СЕРВИС, Асхан, Заамар өгөөмөр хайрхан, АЗАЙШУВУУТАЙН ХӨТӨЛ, Мөнхзогсоол, Ануд номин ХХК-иуд, ХАНГИНАХ ХОРШООг татварын тайлантай тулган шалгаж мэдээлэлд хамруулсан.

БЗД нарын ажилд хяналт мониторинг хийж доорхи үүрэг даалгавар өгөв.ҮҮНД:

- Сумдын багийн Засаг дарга нар нутаг дэвсгэртээ оршин суугаа хүн ам, өрхийг нэг бүрчлэн бүх үзүүлэлтээр бүртгэж, мэдээллийн санг байнга шинэчилэн баяжуулах
- **Баг дээр өдөр бүр ирж үйлчилгээ авч байгаа иргэн бүрээс өрхийн үзүүлэлт болон өрхийн бүх гишүүдийн мэдээллийг нэгбүрчлэн асууж лавлан оруулах.**
- **Хаягандаа амьдардаггүй, гадаадад амьдардаг өрх, иргэдийн төлөвийг солих**
- **ХАӨМС-ийн баяжилт болон засвараа Сумын улсын бүртгэгчтэй төрсөн хүүхэд, нас барсан хүн, шилжин ирсэн, явсан хүнээ иргэн тус бүрээр тулган нягталж ажиллах.**

- Бүртгэлтэй боловч мэдээллийн санд шивж оруулаагүй хүн ам, өрхийг нөхөж оруулах,
- 2018 онд шинээр төрсөн хүүхдүүдийг сар бүр шивж оруулах, нас барсан иргэдийг хасах, шилжилт хөдөлгөөнийг өдөр бүр ХАӨМС-д баталгаажуулах, хүлээгдэж буй шилжилт хөдөлгөөнийг холбогдох багийн Засаг дарга нартай ярьж баталгаажуулах, сумынхаа улсын бүртгэгчтэй хамтарч ажиллан мэдээллийн санд бүртгэлтэй хүн амыг иргэний бүртгэлийн сантай тулгаж шалгах,
- ХАӨМС-ийн тайлан хүснэгтийн хүн ам, өрхийн тайлангийн бүх үзүүлэлтүүдийг нэг бүрчлэн уншуулж эргэлзээтэй мэдээллийг засварлах

ҮСХ-ны ЭЗСГ-ын ахлах шинжээч Р.Энх-Амгалан, ЭЗСГ-ын шинжээч Н.Өлзийханд, ЭЗСГ-ын гэрээт ажилтан Э.Болормаа нартай хамтарч Эрдэнэ, Архуст сумдад 2018 оны 6 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд ажиллаж тооллогын бэлтгэл ажил, зохион байгуулалт, судалгааны асуулгын хуудас нөхөж байгаа байдал, малыг нүдээр үзэж тоолох судалгаанд сонгогдсон өрхүүдээр очиж байгаа эсэх, судалгааны мэдээллийн үнэн зөв байдалд хяналт шалгалт хийж заавар зөвлөмж өгч, тулгамдсан асуудлыг тодорхойлж, хамтарч шийдвэрлэж гарсан алдаа дутагдлыг арилгуулж цаашид анхаарч ажиллах талаар зөвлөмж өглөө.

Сумын статистик хариуцсан ажилтны хөдөө аж ахуй төллөсөн эх мал, төл бойжилт, хорогдсон төл, зүй бусаар хорогдсон том малын мэдээний үндэс, аж үйлдвэрийн мэдээний үндэс, хүн амын онлайн мэдээллийн сангийн ашиглалт, хаягийн өөрчлөлт, өрх, хүн амын шинэчлэлт өөрчлөлт, хүн амын үзүүлэлтийг хэрхэн өөрчилж баяжуулж байгаа, статистик мэдээллийн самбарын баяжилтад 2018 оны 9 дүгээр сарын 10-наас 10 дугаар сарын 25-ны хугацаанд хяналт шалгалт хийлээ. Мөн улсын хэмжээнд явагдах нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд сонгогдсон сум, багийн бэлтгэл ажил хэрхэн хангагдаж байгаад хяналт шалгалт хийж заавар зөвлөгөө өглөө.

Жаргалант, Эрдэнэ, Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан сумдын статистик хариуцсан ажилтан, багийн Засаг дарга нар хамрагдлаа.

Жаргалант суманд хийсэн хяналт шалгалт

Жаргалант сумын статистик хариуцсан ажилтны мэдээний үндэс мөн өгөөмөр баг улсын хэмжээнд явагдах нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаанд сонгогдсон. Түүвэр судалгааны түүврийн хүрээ бэлтгэх, түүний бэлтгэл ажил хэрхэн хангагдаж байгаад хяналт шалгалт хийж заавар зөвлөгөө өглөө. Сумын статистик хариуцсан ажилтан

Г.Энхбаатар ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгч, ажил хүлээлцээгүй статистик мэдээ хариуцсан ажилтангүй байлаа. Тариалалтын эцсийн мэдээг баг тус бүрээр өрх, аж ахуй нэгжээр салгаж шивээгүй нэгтгэл гаргаагүй алдаа дутагдал илэрлээ. Мөн төллөсөн эх мал, зүй бусаар хорогдсон том мал, аж үйлдвэр, улирлын түүвэрт сонгогдсон ТББ-1, АЖ-1 мэдээний үндэс дутуу тамга тэмдэггүй алдаа илэрлээ. Жаргалант сум нь үр тариа, төмс, хүнсний ногоо их хэмжээгээр тариалдаг, хүн ам ихтэй томоохон сумын нэг иймээс статистик мэдээг төрийн албан хаагчид яаралтай хариуцуулж эзэнтэй болгож гарсан алдаа дутагдал, зөрчлийг арилгуулахыг санхүүгийн албаны дарга Долгорцэрэн, сумын ЗДТГ-ын даргын ажил үүргийг түр орлон гүйцэтгэгч Баярсайханд нарт танилцуулж, улсын хэмжээнд явагдах нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны түүврийн хүрээ бэлтгэх, ХАӨМС-ийн шинэчлэлт өөрчлөлт, баяжилт хэрхэн явагдаж байгаа талаар мэдээлэл хийлээ.

Жаргалант сумын Өгөөмөр баг



Иргэдийн мэдээллийг шалгаж шинэчиллээ.



Статистик мэдээллийн самбар

Өгөөмөр багийн 162 өрх, 486 иргэний мэдээллийг шинэчилж цаашид анхаарах асуудлыг багийн ЗД, багийн эрх зүйн хөтчид үүрэг болголоо.

Жаргалант сумын Баянбулаг баг



Баянбулаг багийн иргэдийн мэдээллийг ХАӨМС-нд өөрчлөгдсөн эсэхэд хяналт шалгалт хийлээ.

Эрдэнэ суманд хийсэн хяналт шалгалт

Сумын статистик мэдээ хариуцсан ажилтан Нарантунгалаг болон багийн Засаг дарга нар оролцлоо.

Тамган 5 дугаар багийн ЗД Г.Одсайханы статистик мэдээ болон ХАӨМС-ын баяжилт шинэчлэл өөрчлөлтөд хяналт шалгалт хийлээ. Төллөсөн эх мал, зүй бусаар хорогдсон том малыг өрх тус бүрээр гаргаагүй алдаа дутагдал илэрлээ. Хүн амын онлайн мэдээллийн сангийн баяжилтыг хангалтгүй хийсэн мөн хаягийн өөрчлөлт, хүн амын үзүүлэлтийн алдаа дутагдал илэрлээ. Багийн ЗД Г.Одсайхан түр суугаа төлөвөөр бүртгэгдсэн МСҮТ-ийн оюутны мэдээллийг ХАӨМС-д засварлаж болохгүй мөн шилжүүлэх боломжгүй тухайн иргэн олдохгүй байгаа талаар танилцууллаа. Мөн 2 дугаар багийн ЗД Б.Баттогтох, 4 дүгээр багийн ЗД Оюун-Эрдэнэ нарт хүн амын онлайн мэдээллийн сангийн баяжилт, шинэчлэлт өөрчлөлт, өрх, хүн амын түүвэр уншуулж алдаа дутагдлыг арилгах талаар заавар зөвлөгөө өглөө.



Эрдэнэ сумын Статистик хариуцсан ажилтан, багийн Засаг дарга нар

Эрдэнэ сумын статистик мэдээ, ХАОМС-ын явцад хяналт шалгалт хийж цаашид анхаарах асуудлыг сумын Засаг даргын тамгын газрын дарга Пүрэвсүрэнд танилцууллаа. Статистик мэдээ хариуцсан ажилтан Нарантугалагийн статистик мэдээний үндэс бүрдэл сайн холбогдох бүх мэдээний үндсийг үдэж архивд хадгалсан байлаа. Иргэд болон аж нэгжийн мэдээллийг аж үйлдвэрийн мэдээнд бүрэн хамруулж хэвшсэн байлаа. Хэрэглээний үнийн мэдээг сумын дэлгүүрээс сар бүр бүрэн хамруулдаг. Газар тариалан эрхэлдэг өрх, аж ахуй нэгжийн мэдээллийг хаврын тариалалтын эцсийн мэдээнд бүрэн хамруулсан мөн ургац хураалтын явцын мэдээнд бүрэн хамруулсан байлаа. Төллөсөн эх мал, зүй бусаар хорогдсон том малын нэгтгэлийг өрх бүрээр гаргадаггүй алдаа дутагдал илэрсэн. Энэ нь хагас жилийн малын түүвэр судалгаа болон, жилийн эцсийн мал тооллогод чухал нөлөө үзүүлдэг. Үүнийг засаж залруулахыг статистик хариуцсан Нарантугалагт үүрэг болголоо.

Баян-Өнжүүл суманд хийсэн хяналт шалгалт

Сумын статистик хариуцсан ажилтан Отгонжаргалын статистик мэдээнд хяналт шалгалт хийлээ. Мөн багийн Засаг дарга нарын хүн амын онлайн мэдээллийн сангийн баяжилт өөрчлөлт, нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны түүврийн хүрээ бэлтгэх ажлын явцад хяналт шалгалт хийлээ.

Төллөсөн эх мал, зүй бусаар хорогдсон том малын мэдээг утсаар авдаг өрх тус бүрээр гаргадаггүй мэдээний үндэс дутуу алдаа дутагдал илэрлээ.

Тариалалт эрхэлдэг өрхийн мэдээллийг хаврын тариалалтын мэдээнд бүрэн хамруулсан байлаа. Гарсан алдаа дутагдал түргэн арилгах, цаашид анхаарах зүйлийг Отгонжаргалд үүрэг болголоо.

Төллөсөн эх мал /хаа1/, том малын зүй бус хорогдлын мэдээ /хаа2/, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн мэдээ /хаа3/, тариалалтын явцын мэдээ /хаа6/ тариалалтын эцсийн /хаа7/ мэдээний шалгалт, хүснэгт үр дүнг хөдөө аж ахуйн <http://srv.nso.mn/xaapublish.htm> программаас хэрхэн уншуулж авах мөн хэрэглэгчдэд сар бүр мэдээлж байх талаар заавар зөвлөгөө өглөө.

Статистикийн хэлтсийн www.tuv.nso.mn веб сайт, статистикийн мэдээллийн нэгдсэн сан <http://1212.mn/> сайтаас мэдээлэл хэрхэн авах талаар статистик хариуцсан ажилтан болон багийн Засаг дарга нарт заавар зөвлөгөө өглөө.



**Баян-Өнжүүл сумын багийн Засаг дарга нар
Бүрэн суманд хийсэн хяналт шалгалт**



Статистик мэдээллийн самбар

Тус сумын статистик хариуцсан ажилтан Н.Түвшинжаргалын статистик мэдээг шалгасан. Статистик мэдээг хадгалалт хамгаалалт сайн. Статистикийн тусгай самбартай түүн дээр динамик хүснэгтүүдийг гаргаж тавьсан. Сумаас зээл авч үйл ажиллагаа явуулж буй иргэдийг статистик мэдээнд хамруулдаг.

Мал төллөлтийн явцын мэдээ, том малын зүй бус хорогдлыг мэдээ, хаврын тариалалтын явцын мэдээний үндсийг шалгаж заавар зөвлөгөө өглөө. Мал төллөлт, зүй бусаар хорогдсон том малын мэдээний үндэс тааруу хагас жилийн малын түүвэр судалгаанаас зөрүү гарсан алдаа дутагдал илэрсэнг арилгах цаашид анхаарч ажиллахыг үүрэг болголоо.

Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны түүврийн хүрээ бэлтгэх ажлын явцад хяналт шалгалт хийж Өнжүүл багийн 98 өрх, 236 иргэн, 67 өрх, 17 хаягийн өөрчлөлтийн мэдээллийг шинэчилж цаашид анхаарах ажиллахыг үүрэг болголоо.



Бүрэн сумын багийн Засаг дарга нарын ХАОМС-ын баяжилтыг шалгалаа

Дэлгэрхаан суманд хийсэн хяналт шалгалт


Дэлгэрхаан сумын статистик хариуцсан ажилтан н.Санжааханд, багийн Засаг дарга нарын статистик мэдээг шалгасан. Статистик хариуцсан ажилтан Санжааханд нь 2018 онд статистикийн хэлтэст дамжуулах мэдээний график гаргаж ажил үүргийг хуваарилж сумын Засаг даргын захирамж гарган статистик мэдээний явцыг даваа гариг бүр болдог сумын Засаг даргын тамгын газрын шуурхай хурал дээр танилцуулж ажилладаг. Статистик мэдээний үндэс тааруу ҮСХ-ноос батлагдсан маягтын дагуу мэдээг цуглуулдаггүй алдаа дутагдал гаргасан. Төллөсөн эх мал, том малын зүй бус хорогдлын мэдээг батлагдсан маягтаар цуглуулаагүй программд шууд оруулсан алдаа гаргасныг илрүүлж цаашид анхаарч ажиллах талаар заавар зөвлөгөө өгч гарсан алдааг даруй залруулахыг үүрэг болголоо.

Статистикийн хэлтсийн www.tuv.nso.mn веб сайт, статистик мэдээллийн нэгдсэн сан <http://1212.mn/> сайтаас хэрхэн мэдээлэл авах талаар сургалт хийлээ.

Хөдөө аж ахуйн статистик мэдээний <http://srv.nso.mn/xaapublish.htm> программаас үр дүнгийн хүснэгтийг хэрхэн татаж авах мөн сумын удирдлага, хэрэглэгчдэд тархааж ажиллаж байх талаар заавар зөвлөгөө өглөө.

Улсын хэмжээнд явагдах нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны түүврийн хүрээ бэлтгэх ажлын явц, хүн амын мэдээллийн сангийн баяжилт, шинэчлэл өөрчлөлт явцад хяналт шалгалт хийлээ. Багийн Засаг нар хүн амын төлөвийн өөрчлөлтийг хийж бусад хөдөлгөөнийг хийгээгүй алдаа дутагдал гаргасан.

Дуут-хуримт 2 дугаар багийн 52 өрх, 154 иргэн, 19 хаягийн мэдээллийг шалгаж шинэчлэл өөрчлөлт хийлээ.



Дэлгэрхаан сумын багийн Засаг дарга нарын ХАОМС-ын баяжилтыг шалгалаа.

Аймгийн ХАӨМС-д 2018 оны эхний 12 сарын байдлаар хаягандаа амьдардаггүй 18048 (2147 2017 оны эцэст), гадаадад оршин суугч 1119 (459 2017 оны эцэст), түр оршин суугаа 465 (496 2017 оны эцэст), түр эзгүй 455 (463 2017 оны эцэст) иргэний тэмдэглээг БЗД нараар тэмдэглүүлснээр ӨНЭЗС, АХС-нд нөөц өрхийн сонголтыг 2017 оноос 15-21 хувиар бууруулж чадлаа

СУМЫН СТАТИСТИК ХАРИУЦСАН АЖИЛТАН, БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТ ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

Хөдөө аж ахуйн салбарын статистик мэдээний анхаарах зүйл:

- **Мал төллөлт, бойжилтын /хаа1/ мэдээ** төллөсөн хээлтэгчийн мэдээг гаргахдаа оны эхний төллөх насны хээлтэгчтэй харьцуулж тулгаж шалгаж байх. Төллөсөн хээлтэгчийн мэдээг өрх бүрээр гаргаж нэгтгэлийн дүнг хаа-1 батлагдсан маягтад бүртгэж онлайн программд оруулж байх. Төллөсөн хээлтэгч гарсан төл хоорондын шалгалтыг хийж байх тэмээ, адуу, үхэр ихэрлэсэн алдаа гаргахгүй байх. Бод мал ихэрлэсэн тохиолдолд тайлбар өгч мэдэгдэж байх.

- Хорогдсон төл бойжсон төлөөс илүү гарсан алдаа гарсан.
- **Зүй бусаар хорогдсон том мал /хаа2/** мэдээний анхаарах асуудал. Том малын хорогдлыг өрх бүрээр гаргаж нийт дүнг ҮСХ-ноос батлагдсан ХАА-2 маягтад бүртгэж онлайн программд оруулж байх. Хагас жилийн малын түүвэр судалгаа болон жилийн эцсийн мал тооллогын шалгалтыг явцын мэдээ ХАА1, ХАА2 мэдээтэй баг тус бүрээр тулгаж шалгалт хийгддэг. Явцын мэдээний чанар тааруу байгаагаас болж мал тооллогоор алдаа дутагдал ихээр гардаг. Хагас жилийн малын түүвэр судалгаанд сонгогдсон өрхийн мэдээллийг жилийн эцсийн мал тооллогоор тулгаж шалгахад маш их алдаа илэрч байгаа болно.
- **Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн /хаа3/** мэдээний хэмжих нэгж болон оронгийн алдаа гаргахгүй байх. Мөн хамралтыг нэмэгдүүлэх боодлын өвс, задгай өвс, аргал хөрзөнгийн мэдээг сар бүр хамруулж байх.
- **Хаврын тариалалтын явцын мэдээ /хаа6/.** Тариалалтын мэдээг багийн Засаг дарга нараас гаргуулан шалгаж хүлээн авсны дараа онлайн программд оруулж гарсан алдаа дутагдлыг тухай бүр засаж залруулж мэдээ дамжуулсны дараа өмнөх онтой харьцуулсан тайлбар ирүүлж хэвших. Мөн хөдөө аж ахуйн газрын мэдээтэй тулгаж мэдээний зөрүү гаргахгүй байх тал дээр анхаарах.
- **Тариалалтын эцсийн /хаа7/ мэдээ.** Тариалалтын эцсийн мэдээг өрх, аж ахуй нэгж тус бүрээр онлайн программд оруулсны дараа тариалалтын явцын /хаа6/ мэдээтэй шалгахад ургамлын төрөл өөрчлөгдсөн, усалгаатай талбай буурсан, хүлэмжийн талбай буурсан, нийт тариалсан талбай хэт их өсөх эсвэл хэт их буурсан алдаа дутагдал маш гарсан.
- **Ургац хураалтын явцын /хаа8/ мэдээ.** Ургац хураалтын явцын мэдээг багийн Засаг дарга нараас гаргуулан шалгаж хүлээн авсны дараа онлайн программд оруулж гарсан алдаа дутагдлыг тухай бүр засаж залруулж мэдээ дамжуулсны дараа өмнөх онтой харьцуулж хэт их өссөн, буурсан тохиолдолд заавал тайлбар ирүүлж хэвших. Хураасан талбай тариалсан талбайгаас илүү гарсан алдаа дутагдал гарсан. Мөн хөдөө аж ахуйн газрын мэдээтэй тулгаж мэдээний зөрүү гаргахгүй байх тал дээр анхаарах.
- **Ургац хураалтын эцсийн /хаа9/ мэдээ.** Ургац хураалтын эцсийн мэдээг явцын /хаа8/ мэдээтэй маш сайн тулгаж шалгаж байх. Оронгийн алдаа болон хэмжих нэгжийг сайтар анхаарах. Хураасан га-ийн хэмжээг тариалсан га-ийн хэмжээтэй уялдуулан шалгаж га-аас хураан авсан нэгжийн ургацыг шалгаж тухай бүрд тайлбар ирүүлж байх. Хүнсний ногоон дээр нэгжийн ургацыг тусгайлан сайтар шалгаж үзэх. Гар тэжээл, бэлтгэсэн өвс, хужир шүүг бүрэн хамруулах.

БУСАД АЖИЛ

- Нутгийн захиргааны ордонд байрладаг хэлтэс, агентлагуудын дунд зохион байгуулдаг спортын 5 төрөлт тэмцээнд АЗДТГ-ын хэлтэс, агентлагуудтай хамтран баг болж 1 удаа оролцлоо.
- МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар “Бүх нийтээр мод тарих өдөр”-өөр Зуунмод цэцэрлэгт хүрээлэнд албан хаагчид 2 удаа нийт 42 мод тарилаа.
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хэлтсийн албан хаагчдын 0-16 насны 11 хүүхдүүдэд 225000 ₮-ийн бэлэг гардууллаа. Хэлтсийн 2 өндөр настанд сар шинэ, ахмадын өдрөөр хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.
- Хэлтсийн албан хаагчдын цай, кофены зардал, гамшгаас хамгаалах бэлэн байдлын хувцас хэрэгслийн зардал, “Байгаль нуурын аялал”-д нийт 2636.6 мянган төгрөг зарцуулав.
- Сумдын 2017 оны статистикийн ажлыг дүгнэн эхний 5-д орсон Эрдэнэ, Заамар, Цээл, Батсүмбэр, Баянцогт сумын статистик хариуцсан ажилтан Г.Нарантунгалаг, М.Балжинням, Д.Нарангэрэл, Д.Оюунчимэг, Э.Эрдэнэжаргал нарыг 80-50.0 мянган төгрөг, нийт 310.0 мянган төгрөгөөр урамшуулав.
- ҮСХ-ны Санхүүгийн албанаас 2016, 2017 он, 2018 оны 1-4-р сарын санхүүгийн баримтанд хяналт хийхэд ямар нэгэн зөрчил гараагүй, өгсөн зөвлөмжийг санхүүгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаа.
- ҮСХ-ны НСГ-ын дарга А.Амарбал, ахлах статистикч Э.Гантуяа, ахлах шинжээч Д.Анхзаяа, Б.Уламбадрах нар Зуунмод, Батсүмбэр суманд АХС-ны туршилтын маягтыг өрхүүдээр газар дээр нь очиж танилцан дэлгэрэнгүй асуулт хариултыг хийж мэдээлэл цуглууллаа.
- ҮСХ-ны ЭЗСГ-ын үнийн албаны ахлах статистикч Д.Энхзаяа, шинжээч, Д.Батсүх нар хэлтэс болон Зуунмод суманд үйлдвэрлэгчийн үнийн бүх мэдээний гаргалтанд мониторинг хийж, сонгогдсон цэгүүдээр явж танилцан, анхаарах асуудлаар зөвлөмж өгсөнг хэрэгжүүлсэн.
- ҮСХ-ны референт Г.Дамдин, ажилтан Энхбат нартай хамтарч мал тооллогын шторк хийж сурталчилгаанд ашигласан.
- Салбарын шагнал ҮСХ-ны "Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан" цол тэмдгээр Батсүмбэр, Эрдэнэ, Борнуур, Цээл сумдын статистик хариуцсан ажилтан Д.Оюунчимэг, Г.Нарантунгалаг, Н.Шинэбаяр, Д.Нарангэрэл нар, ҮСХ-ны "Хүндэт жуух"-аар Баянцагаан, Баянчандмань статистик хариуцсан ажилтан Ц.Цэндсүрэн, Н.Юмсүрэн нар, Эрдэнэ, Батсүмбэр, Борнуур, Жаргалант сумдын

багийн Засаг дарга С.Эрдэнэбаатар, Ш.Сарангэрэл, Б.Цэвэлсүрэн, Д.Майдар, ЭМГ-ын статистик хариуцсан ажилтан Н.Мягмарсүрэн, Зуунмод сумын багийн бүртгэл мэдээллийн ажилтан Д.Энхтуул, Д.Санжаасүрэн нар, Аймгийн ЗД-ын хүндэт жуухаар хэлтсийн мэргэжилтэн Б.Энхтүвшинг тус бүр шагнууллаа.

- 2018 оны аймгийн шилдэг статистикийн ажилтнаар Заамар сумын статистик хариуцсан ажилтан М.Балжинням шалгарч цом 150 000 ₮-өөр шагнагдсан.
- БНСУ-ын Статистикийн газрын Нийгмийн статистикийн товчооны дарга Кан Чан Шиг тэргүүтэй төлөөлөгчид хэлтсийн үйл ажиллагаатай танилцлаа Энэ удаагийн уулзалтаар хөдөө аж ахуйн статистик болон өрхийн орлого, зарлагын судалгааны хүрээнд харилцан туршлага судлах юм. Хэлтсээс орон нутгийн салбарын үйл ажиллагааны чиглээр дэлгэрэнгүй мэдээлэл хийж Төв аймгийн эдийн засгийн үндсэн 2 салбар болох мал аж ахуй, газар тариалангийн үзүүлэлтүүдийг танилцуулж, мал тооллого болон өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны цахим программ хангамжийн ашиглалт, хэрэглээний одоогийн түвшин, тулгарч буй сорилт бэрхшээлийн талаар мэдээлэл өгч, санал солилцлоо.



Мал тооллогыг хэрхэн хийдгийг газар дээр нь үзүүлээ.

Шинээр хийгдсэн ажлууд

Багаар

- Хураасан ургац, ургамлын төрлөөр-багаар 2014-2017

2016 оны аж ахуйн байгууллагын улсын тооллого

- 2.1. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР
- 2.2. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР
- 2.3. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО, ХАРИУЦЛАГЫН ХЭЛБЭР, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР
- 2.4. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, ХАРИУЦЛАГЫН ХЭЛБЭР, ӨМЧИЙН ТӨРЛӨӨР

- 2.5. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР
- 2.6. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, ХАРИУЦЛАГЫН ХЭЛБЭР, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР
- 2.7. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, ӨМЧИЙН ТӨРӨЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР
- 2.8. ХУВИЙН СЕКТОРЫН АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР
- 2.9. БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮЛЭГ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР
- 2.10. ТЭЭВЭР, АГУУЛАХ, МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭД САЛБАРААР
- 2.11. ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ ХУУЛИЙН ЭТГЭЭД ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮЛЭГ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР
- 2.12. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛЭГ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР
- 2.13. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР
- 2.14. ХУУЛИЙН ЭТГЭЭД АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН БҮЛЭГ, САЯ ТӨГРӨГ
- 2.15. ХУУЛИЙН ЭТГЭЭД АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН БҮЛЭГ, САЯ ТӨГРӨГ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР портал сайтыг баяжууллаа.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэл ажлын хүрээнд

ХАӨМС-гийн 27 сум, 97 багийн

Хүн амын үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн дундаж хувь 46.47, нийт 43982 иргэний

Өрхийн үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн дундаж хувь 21.45, нийт 6431 өрхийн мэдээллүүдийг тус бүр шинэчлэлт өөрчлөлт хийлгүүллээ.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс